- Химийн бодистой холбоотой үйл ажиллагаа (ашиглах, хадгалах) явуулж байгаа газрууд, агуулахуудад хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх,
- Аянга зайлуулагчийг тэсэрч дэлбэрэх аюултай химийн бодистой холбоотой үйл ажиллагаа явагдаж байгаа бүх газруудад байрлуулах, Химийн бодисын нэг агуулахад 500 тонноос, агуулахын доторхи нэг тасалгаанд 50 тонноос ихгүй бодис хадгалбал зохино.
- Бүх химийн бодис, ялангуяа шатамхай шингэнийг халаалтын хэрэгсэл, цахилгааны эх үүсвэр, системээс хол, шууд нарны гэрэл тусахааргүй нөхцөлд хадгална,

Хөрсөн бүрхэвч

“Эс Жи Эс Эм Эм И Монголиа” ХХК-ийн Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лабораторийн талбайн нь бүхэлдээ хатуу хучилт бүхий учир хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл маш бага юм. Лабораторийн эзэмшил талбайн хэмжээнд нийт талбайг хатуу хучилтаар хучсан тул хэрэглэгдэх химийн бодисуудаас хөрсний чанарт цөөн хэдэн хучин зүйлсээр нөлөөлөхөөр байна. Орчны хөрсний чанарт химийн бодисуудын тээвэрлэлт, ашиглалт, хадгалалтаас үүсэх болзошгүй нөлөөллүүдийг доор үзүүлэв. Үүнд:

- Төслийн барилга байгуулалтын ажилд хэрэглэгдэж байгаа бодисын хадгалалт, агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийг төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн хөрсөнд их хэмжээгээр химийн бодис алдагдах

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

- Тээвэрлэлт, түгээх, хүлээн авах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодисыг хөрсөнд алдаж, түүний найрлага бүтцийг өөрчлөх,
- Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдсанаар ургамалжилт, гадаргын болон газар доорх ус, ургамал амьтанд дам нөлөөлөл үзүүлэх зэрэг болно.
- Тээврийн хэрэгслийн тоо нэмэгдэх нь тухайн бүсийн хөрсний бохирдол өсөх, бохирдуулагч бодисын хуримтлал үүсэх нөхцлийг бий болгох бөгөөд ингэснээр, хөрсөн дэх техноген бохирдуулагч бодисын хэмжээ нэмэгдэх,
- Автомашины утаанаас гарах хар тугалга зэрэг хорт бодис нь зам орчмын хөрсөнд, хүний эрүүл мэндэд муугаар нөлөөлөх
- Хадгалалтын шаардлага хангаагүй бодисын химийн нэгдэл хур борооны болон чийг авснаас урсаж хөрс бохирдуулах

Химийн бодисын аюулгүй ажиллагаа, түүнийг зөрчсөнтэй холбоотой осол аваар нь голдуу техник, технологийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны горим алдагдснаас үүдэлтэй байдаг. Иймд химийн бодис тээвэрлэх, хадгалах, ашиглах болон ус ах журманд заагдсаны дагуу алдаж асгахаас сэргийлэх арга хэмжээ авах хэрэгтэй. Үүнд:

- Химийн бодистой холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа агуулах, газруудын шалыг химийн үйлчлэлд тэсвэртэй зузаан материалаар хийх. Нэвчилт, алдагдлыг байнга шалгаж, шаардлагатай бол арга хэмжээ авах,
- Химийн бодис хадгалж байгаа болон ашиглаж буй газар үерийн хамгаалалт, даланг инженерчлэлийн нарийвчилсан үндэслэл тооцоотой хийж өгөх. Барилгын материалын цэг, шатах тослох материал, химийн бодисуудыг хадгалах цэгүүдийг ус нэвчүүлэхгүй байхаар тохижуулах, агуулах саванд тогтмол үзлэг хийж хянаж байх,
- Шингэн хаягдал хаях цэгийг хөрсөнд үл нэвчүүлэх материалаар (шавар, элс) зузаан доторлож, хальж асгарахаас сэргийлэн, түвшинд байнга хэмжилт хийж байх,
- Хөрс, болон усан орчинд химийн бодис алдагдсан тохиолдолд тухайн бодисыг цаашид тархахаас нь сэргийлж, шингээн авах шаардлагатай. Ямар бодис алдагдсанаас шалтгаалан шингээж авах материалын нэр төрөл өөрчлөгдөх ба голдуу гадаргуугийн идэвхтэй, инерт, саармаг материалыг мөн элс, шороо зэрэг элбэг байх материалуудыг ашигладаг.

Гадаргын болон газрын доорх ус

"Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лаборатори" төслийн үйл ажиллагаанд шаардагдах ахуйн болон технологийн усыг Улаанбаатар хотын төвлөрсөн ус хангамжийн Системээс хангадаг. Төслийн үйл ажиллагааны үед ахуйн бохир ус дамжуулах хоолойн бүрэн бүтэн байдал алдагдсанаас газрын доорх усны чанарт шууд сөргөөр нөлөөлнө. Гэхдээ үйлдвэрийн талбай нь бүхэлдээ хатуу хучилт бүхий учир алдагдсан химийн бодис газрын доорх усанд нэвчих хурд бага юм. Иймд нөлөөллийн эрчим бага бөгөөд хэрвээ газрын доорх усанд алдагдах нөхцөлд удаан хугацаанд хадгалагдах магадлалтай юм. Орчны усны найрлага, чанарт химийн бодисуудын тээвэрлэлт, ашиглалт, хадгалалтаас үүсэх болзошгүй нөлөөллүүдийг доор үзүүлэв. Үүнд:

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

- Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдолоос үүдэн гадаргын түр урсацад химийн бодис орох, улмаар түүний урсацаар тархах,
- Тээвэрлэлт, түгээх, хүлээн авах үйл ажиллагааг шаардлагын дагуу зөв явуулаагүйгээс химийн бодис асгарах, талбайд татан ирэх явцад түр зуурын үерт өртөж, тухайн урсацын усыг бохирдуулах, бохирдлын эх үүсвэр бий болгох,
- Химийн бодис ашиглаж байгаа газруудад хэрэглээний нормоос илүү болон ашиглалтгүй химийн бодисын хуримтлал үүссэнээс хур бороо орж гадаргын ус үүссэн үед уг усыг бохирдуулах. Мөн тухайн цэг химийн бодисоор бохирдсон усыг технологийн горим зөрчиж хөрс, түр зуурын урсацын гольдролд алдсанаас гадаргын болон газар доорх ус бохирдох зэрэг болно.
- Хортой, аюултай бодисын хадгалалт, устгалын шаардлага хангаагүйгээс хортой, аюултай химийн бодис, эсвэл хоорондоо үл нийцэх бодисууд нэгдэж болзошгүй аюул бий болох, ашигласан бодисуудын хаягдлыг устгалын шаардлага хангахгүйгээр шууд хаяснаар усан орчинд шууд болон дам нөлөө үзүүлэх
- Технологийн хэрэглээний явцад хэрэглэсэн бодисыг саармагжуулж, хоргүйжүүлээгүйгээс хортой нэгдэл үүсэх, хорын тархалт бий болох

Нийт нөлөөллийн 100 хувь нь "бага" үр дагавартай байгаагаас химийн бодисын гадаргын болон газар доорх усанд нөлөөлөх нөлөөллийг "дунд" зэрэг гэж үзлээ. Иймд сөрөг нөлөөллийг арилгахад дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

- Бүх төрлийн шингэн хаягдал хаях цэгийг хөрсөнд үл нэвчүүлэх материалаар (шавар, элс) зузаан доторлож, хальж асгарахаас сэргийлэн түвшинд байнга хэмжилт хийж байх. Хэрэглээнээс илүү гарсан, хаягдал бодис материалуудыг зохих жураманд заагдсан дагуу тээвэрлэх /Байгаль орчны сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын 2007 оны 04 дугаар сарын 27-ны өдрийн 151/126/52 дугаар хамтарсан тушаалын хавсралт/.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Эс Жи Эс Ай Эм Эм И Монголиа ХХК-ийн Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лаборатори төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийг тооцож энэхүү бүлэгт оруулав.

3.1. Төслийн гол сөрөг нөлөөлөл

Төслийн гол сөрөг нөлөөлөл Сөрөг нөлөөлөл гэдэг нь иргэн аж ахуйн нэгжийн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засгийн төлөв байдалд таагүй буюу сөрөг өөрчлөлт гарахыг хэлнэ. Тэгвэл сөрөг нөлөөллийн үнэлгээгээр тэдгээр өөрчлөлтийн болзошгүй байдлыг тодорхойлдог ба сөрөг нөлөөлөл нь голлох эсвэл дам байдлаар илэрч болно. "Эс Жи Эс Ай Эм Эм И Монголиа" ХХК-ийн Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лабораторийн байгаль орчинд нөлөөлөх гол сөрөг нөлөөллийг дараах байдлаар авч үзэв. Үүнд:

1. Лаборатори нь байгаль орчинд идэвхтэй үйл ажиллагаа явуулахгүй ч хортой, аюултай бодис, материалын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт, устгалын үед бий болох гол сөрөг нөлөөлөл
2. Хортой, аюултай бодис, материалын хадгалалт, тээвэрлэлт, устгалын аюулгүйн шаардлага зөрчигдсөнөөс үүсэж болох болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Дээрх сөрөг нөлөөллийн гол болон дам сөрөг нөлөөлөл:

1. Автотээврийн хөдөлгөөн, илүүдэл дээжийн хуримтлал, химийн бодис ачиж буулгах, ил задгай хадгалах нөхцөлд агаарын тоосжилт бий болох, мөн хортой аюултай химийн бодисын хадгалалтын шаардлага хангаагүйгээс аюултай бодис уурших, улмаар ууршилт, тоосжилтоос агаар бохирдох, тэсрэх аюулыг бий болгох
2. Мэргэжлээс шалтгааласан өртөлтийн зэрэг өндөр байх магадлалтай. Тухайлбал ажлын байран дахь хамгийн нийтлэг өртөлтийн замууд болох амьсгалын зам болон арьсаар өртөх өртөлтүүд их байх болно. Арьсаар дамжин химийн бодисын нөлөөлөлд өртөхөд хэсгийн нөлөөлөл буюу тухайн өртсөн хэсгийн арьс загатнах, эсвэл үрэвсэхэд хүргэж болно.
3. Ажилтнуудын болгоомжгүй үйл ажиллагаа, техникийн гэмтэл, саатал болон байгалийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас жишээлбэл үер, аянга цахилгаан, хүчтэй салхи шуурга зэргээс гал алдах, их хэмжээний тэсрэлт, дэлбэрэлт үүсч байгаль орчин, хүний амь нас, эд хөрөнгөд хохирол учрах
4. Бүрэн бус тээврийн хэрэгсэл, аюулгүй ажиллагааны дүрэм баримтлаагүйгээс химийн бодис тээвэрлэх, ачиж буулгах үед хөрсөнд химийн бодис бүтээгдэхүүн асгарах, агуулах орчимд гал өдөөгч бий болгох, тухайлбал яндангаас гарах оч, техник хэрэгслийг засварлах үед гал алдах гэх мэт
5. Хортой, аюултай бодисын хадгалалт, устгалын шаардлага хангаагүйгээс хортой, аюултай химийн бодис, эсвэл хоорондоо үл нийцэх бодисууд нэгдэж, болзошгүй аюул бий болгох, ашигласан бодисуудын хаягдлыг устгалын шаардлага хангахгүйгээр шууд хаяснаар үүдэн гарах сөрөг нөлөөллүүд байна.

3.2. Төслийн болзошгүй нөлөөлөл

Төслийг хэрэгжүүлэхэд байгаль орчин болон ард иргэдэд нөлөөлж болзошгүй гол хүчин зүйл нь химийн бодисын ачиж буулгах үед анхаарал болгоомжгүйн улмаас химийн бодис асгарах асуудал байна. Үүнтэй холбогдуулан сөрөг нөлөөллийн түвшин их, дунд, бага, нөлөөлөлгүй гэсэн үзүүлэлтээр нөлөөллийн үнэлгээг нарийвчлан хийж, сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжийг гаргав. Төслийн төлөвлөгдсөн технологийн шийдэл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, сөрөг нөлөөлөл, эрсдэлийг бууруулах талаарх мэргэжлийн байгууллагын зүгээс өгсөн санал, зөвлөмжийг мөрдөн ажилласан тохиолдолд сөрөг нөлөөллийн түвшин буурах боломжтой.

3.3. Экологийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдэд төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөлөл

3.3.1 Төслөөс агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Химийн бодисын агуулахад хадгалагдах бодисуудыг хадгалахдаа аюулгүйн ажиллагааны дүрмийг баримтлаагүй улмаас химийн бодис ихээр алдагдсанаар агаарт дэгдэж хүний эрүүл мэндэд нөлөөлж болох ба бодис алдагдсан цаг тухайд саармагжуулах аргыг хэрэглэвээс нөлөөллийн үргэлжлэх хугацаа нь харьцангуй бага байна. Мөн хог хаягдлыг ил задгай зөвшөөрөгдсөн ангиллын дагуу бус устгаснаас нөлөөлөл үүсэж болзошгүй юм. Агаарын бохирдол нь хамрах хүрээ хязгаарлагдмал, бодис бүрийг зөвшөөрөгдсөн аргачлалын дагуу устгавал агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл бага болно.

3.3.2. Төслөөс усны чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

"Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лаборатори" төслийн үйл ажиллагаанд шаардагдах ахуйн болон технологийн усыг Улаанбаатар хотын төвлөрсөн ус хангамжийн системээс хангадаг. Төслийн үйл ажиллагааны үед ахуйн бохир ус дамжуулах хоолойн бүрэн бүтэн байдал алдагдсанаас газрын доорх усны чанарт шууд сөргөөр нөлөөлнө. Гэхдээ үйлдвэрийн талбай нь бүхэлдээ хатуу хучилт бүхий учир алдагдсан химийн бодис газрын доорх усанд нэвчих хурд бага юм.

3.3.3. Төслөөс хөрсөн бүрхэвчид үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

"Эс Жи Эс Ай Эм Эм И Монголиа" ХХК-ийн эзэмшил талбай Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт орших бөгөөд 9720 м² талбайг хамаарна. Газарзүйн мужлалаар ордын дүүрэг нь Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэгт харъяалагдана.

"Эс Жи Эс Ай Эм Эм И Монголиа" ХХК-ийн Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лабораторийн талбайн нь бүхэлдээ хатуу хучилт бүхий учир хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл маш бага юм.

3.3.4. Төслөөс ургамал, амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Судалгааны объект нь ургамал-газарзүйн мужлалаар Евро-Азийн хээрийн их муж, Монгол Дагуурын уулын ойт хээрийн тойрог, Хэнтийн уулын тойрог, Хэнтийн нурууны баруун зах, Туул голын районд хамрагдана. Бидний судалгааны нэг объект нь ургамалжилт нь хуурай хээрийн эвшилд хамаарах бөгөөд хотын суурьшлын бүсэд тул ургамлан бүрхэвч шарилж, үетэн бүлгэмдэл давамгайлдаг байна. Хашааны булан тойгоор шарилжит бүлгэмдэл тархсан байна.

Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдал, үнэлгээ

"Эс Жи Эс Ай Эм Эм и Монголиа ХХК-ийн Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лабораторийн байгууламж нь 9720м² талбайг түрээслэн үйл ажиллагаа явуулж байна. Уг төслийн талбай нь удаан хугацаанд хүний үйл ажиллагаанд тогтвортой ашиглагдсан төдийгүй барилга байгууламж нэгэнт баригдсан тул байгалийн ургамалжилттай талбай одоогоор байхгүй. Иймд ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй юм.

3.3.5. ТХГН, түүх, соёлын дурсгалт зүйлст үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лаборатори байрших талбай нь тусгай хамгаалалттай газар нутгийн талбайд хамаарахгүйн дээр ойр орчимд нь түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс илрээгүй болно.

3.3.6. Төслийн нийгэм эдийн засгийн нөлөөлөл

Төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмийн албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу тооцоолон татвар хэлбэрээр улс болон орон нутгийн төсвийн санд оруулна. Төсөл хэрэгжих бүх жилийн хугацаанд НӨАТ, НДШ, ХАОАТ, ашгийн татвар, үл хөдлөх хөрөнгийн татвар, тусгай зөвшөөрлийн төлбөр гэх мэтээр улсад татварууд төлнө.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Эс Жи Эс Ай Эм Эм И монголиа” ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 Дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лабораторийн төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасан төлөвлөгөөг ойлгоно. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

“Эс Жи Эс Ай Эм Эм И монголиа” ХХК ХХК-ийн Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лабораторийн төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгалаа.

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд галын хор, гал унтраах хэрэгслээр хангах, усан хангамжаа хангаж буй усанд хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх, технологийн хэрэгцээнд ашигласан усыг цэвэршүүлэн саармагжуулах, агуулахын орчны зам талбайг хатуу хучилттай болгох зэрэг ажлын төлөвлөлөө.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, Мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, Мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
5.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
1	Химийн бодис, бүтээгдэхүүний хаягдлын тоосжилт, ууршилт бүхий хэсгүүд салхиар дамжин хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй. Агуулахад хадгалагдаж буй шингэн, хуурай нунтаг Агаарын бохирдлыг хэмжих мониторинг хийх	Ажилтан тээвэрлэж буй машин, техникийн засвар үйлчилгээг тогтмол хийж хорт хий ялгаруулалтад хянат тавьж багасгах арга хэмжээг авах	Эс Жи Эс Ай Эм Эм И Монголиа ХХК-ийн машин механизм	Км			160,0	Жил бүр	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль,
		Химийн бодисын алдагдалын үед хэрэглэх арчих материалыг бэлэн байдлыг хангах	Эс Жи Эс Ай Эм И Монголиа ХХК-ийн төслийн талбай		300.0	1	300.0	6-10 сар	MNS 4585-2016 Агаар орчны чанарын үзүүлэлт, ерөнхий шаардлага MNS0012-013:91 Ажлын бүсийн агаар. Эрүүл ахуйн шаардлага
		Галын хор, гал унтраах	Эс Жи Эс Ай Эм		200		200	Хуучин байгааг	

**Баянгол дүүргийн 20-р хорооны нутагт байрлах Эс Жи Эс Ай Эм Эм И
Монголиа ХХК-ийн Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн
лабораторийн төслийн**

2024 он

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		хэрэгсэлээр хангах	Эм Монголиа ХХК-ийн төслийн талбай	И				цэнэглэх, шалгах	
5.2. Гадаргын болон газрын доорх усны нөөцөд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
3	Ус ашиглалтын төлбөрийг худгийн усны тоолуураар тооцон цаг тухай бүрт төлж байх	Усан хангамжаа хангаж буй усанд хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Худгийн ус	М					УСУГ-н нэхэмжлэлийн дагуу төлбөр төлөх
4	Усан орчин бохирдуулах	Технологийн хэрэгцээнд ашигласан усыг цэвэршүүлэн саармагжуулах	Хаягдал ус				1.000.00	Өдөр тутамд	
5.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
3	Хөрс бохирдохоос сэргийлэх	Агуулахын орчны зам талбайг хатуу хучилттай болгох.	Хөрсөн бүрхэвч		1.200.0		1.200.0	1 удаа	Хөрсний бохирдуулалтын стандарт 5850-2019
4		Мод ургамал тарих	Төслийн талбайд		200.0		200.0	1 удаа	
	Нийт						3 060'000		

БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд нийт талбайн сул чөлөөтэй хэсэг буюу агуулахын эргэн тойронд мод бут сөөг тарих нөхөн сэргээх ажлыг MNS 4918:2000 стандартын дагуу ургамалжуулалт, ногоон байгууламж, мод тарих ажлыг үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төслийн талбайн сул чөлөөтэй хэсэг агуулахын эргэн тойронд нийт 100 м ² талбайд ногоон байгууламж байгуулах	Ногоон байгууламж байгуулах нийт 100 м ² талбайд MNS 4918:2000 стандартын дагуу тарималжуулах шаарлагатай талбайн 60% буюу 60 м ² талбайд ургамалжуулалт буюу олон наст ургамал тарина.	60 м ² талбайд: Нөхөн сэргээх ажлын зардлын үнэлгээнд зааснаар 1.0 га талбайд 18-20 кг олон наст ургамлын үр тариалдаг нормтой байна.	кг	0.108	15000 төгрөг	160.0	4-р улиралд багтаана.	MNS 5918:2008 ургамалжуулах стандарт MNS 5973 : 2009 Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг төлөвлөхөд ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ MNS6253-2: 2011 мод, сөөг тарих
		Ногоон байгууламж байгуулах нийт 100 м ² талбайн	40 м ² талбайд. 1.0 га талбайд мод, бутны суулгац 4500-	ш	5	50000 төгрөг	250.0	4-р улиралд багтаана	

**Баянгол дүүргийн 20-р хорооны нутагт байрлах Эс Жи Эс Ай Эм Эм И
Монголиа ХХК-ийн Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн
лабораторийн төслийн**

2024 он

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	40% буюу 40 м ² талбайд мод, бут тариална.	5000 ширхэг байхаар тооцоолон тарьдаг байна.						MNS 5994:2009 үрээр тарих MNS 5918:2008 ургамалжуулах стандарт MNS 4918:2000 MNS 5973 : 2
Нийт						410.0		

БҮЛЭГ 7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лаборатори төслийн талбайд дахиж шинээр барилга байгууламж баригдахгүй тул түүх соёлын арга хэмжээг төлөвлөөгүй болно.

БҮЛЭГ 8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү төслийн агуулах талбай нь Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо, 9720 м² талбайд байрлана. “Эс Жи Эм-Ай Эм И Монголиа ” ХХК-ийн Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лабораторийн үйл ажиллагааны явцад ажилчдын аюулгүй байх орчин нөхцөлийг ханган хөдөлмөр хамгаалал, осол аюулгүйн талаарх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах багасгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах хууль, журам, стандарт
1	Болзошгүй осол, саатал, техник тоног, төхөөрөмжийн гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Төслийн хүрээнд ашиглагдах тоног төхөөрөмж, техник	Төслийн өдөр тутмын үйл ажиллагаа			2024 он	Гамшгаас хамгаалах тухай хууль
		Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг зохион байгуулах, холбогдох дүүргийн байгаль орчны алба, байгаль хамгаалагч	Нийт ажилчид	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгасан			2024 он	

**Баянгол дүүргийн 20-р хорооны нутагт байрлах Эс Жи Эс Ай Эм Эм И
Монголиа ХХК-ийн Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн
лабораторийн төслийн**

2024 он

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		нартай харилцан холбоотой ажиллах						
2	Ажилчдын эрүүл мэнд аюулгүй ажиллагаа	Бодис урвалжуудын хор аюулын зэргийг харуулсан тэмдэг, тэмдэглэгээг монгол тайлбараар дэлгэрэнгүй хийх	Төслийн талбайн барилга байгууламж	50.0	4	200.0	2024	MNS 5029:2011. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг.
		Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд худалдан авч байршуулах	Агуулах	60.0	Жилд нэг удаа	200.0	2024	
		Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр, хангах	Нийт ажилчид	Үйл ажиллагааны зардлаар			2024 он	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 15-дугаар зүйл
		Аюулгүй ажиллагааны дотоод журам боловсруулж мөрдүүлэх	Агуулахын хүрээнд	Үйл ажиллагааны зардлаар			2024 он	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 27.3.4, 28.1.8
Нийт					400.0			

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

БҮЛЭГ 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лаборатори төслийн хүрээнд ахуйн хэрэглээний хог хаягдлыг ангилж Баянгол дүүргийн ТҮК сард 2 удаа тээвэрлүүлэхээр төлөвлөсөн. Мөн аюултай хог хаягдлыг Цэцүүх трейд ХХК-тай гэрээ байгуулан улиралд 1 удаа тээвэрлүүлэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн	Харьяа газрын ТҮК-тэй хийсэн хог тээрийн гэрээний дагуу зайлуулах	Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэнд	тн	Үйл ажиллагааны зардалд тусгах			Сард 2 удаа	Хог хаягдлын тухай хууль
	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах ялгах хогийн сав авч байршуулах		ш	50.0	6	300.0		
	Харьяа газарт байрлах мэргэжлийн байгууллагатай бохир ус соруулж зайлуулах гэрээ байгуулах		тн	-	-	100.0	Сард 2 удаа	
Аюултай	Химийн бодисын сав баглаа боодлыг химийн хортой, аюултай бодис устгах, дахин тээвэрлэх, боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн	Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэнд	ш		Гарсан химийн бодисын сав баглаа боодлын хэмжээгээр тооцож төлөх -	1200.0	Улиралд 1 удаа	Хог хаягдлын тухай хууль

Баянгол дүүргийн 20-р хорооны нутагт байрлах Эс Жи Эс Ай Эм Эм И
 Монголиа ХХК-ийн Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн
 лабораторийн төслийн

2024 он

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	байгуулалтай байгуулж устгах	гэрээ							
Нийт							1600.0		

БҮЛЭГ 10. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лабораторийн үйл ажиллагаанд 223 нэр төрлийн химийн бодис ашиглана.

Хүснэгт 9. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо, хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Химийн бодисын хадгалалт, ашиглалтын стандарт, дүрэм журам мөрдөөгүй улмаас эрсдэл үүсэх	Химийн бодис бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалт, ашиглалт, зарцуулалтад хяналт тавих	Сургалт зохион байгуулах ба бүртгэлжүүлэх	Удаа	150.0	Улиралд 4	600.0	Жил бүр	Химийн хот болон аюултай бодисын тухай хууль
Химийн бодисын сав баглаа боодлын хаягдлаас бохирдол үүсэх агсарч гоожих	Лабораторид хэрэглэгдсэн химийн бодисын сав баглаа боодлыг мэргэжлийн байгууллагад шилжүүлж устгуулах	Химийн бодисын сав баглаа боодол	Удаа		Жилд 4 удаа	Хог хаягдлын төлөвлөгөөнд тусгагдсан	Жил бүр	Химийн хот болон аюултай бодисын тухай хууль
Лабораторид ажиллаж байгаа ажиллагсад	Баяжуулах үйлдвэрийн химийн бодистой	Баяжуулах үйлдвэр ба лаборатори	ш	170.0	4	680		

Баянгол дүүргийн 20-р хорооны нутагт байрлах Эс Жи Эс Ай Эм Эм И
Монголиа ХХК-ийн Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн
лабораторийн төслийн

2024 он

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

хордох эрсдэлд өртөж болзошгүй	харьцан ажиллаж байгаа ажиллагсдыг хор саармагжуулах бүтээгдэхүүнээ р хангах							
	Нийт зардал					1280.0		

БҮЛЭГ 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг **“Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”** гэнэ. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тухайн төслөөс байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг /ус, хөрс, ургамал гэх мэт/ тус бүрд гарах бохирдол, аливаа өөрчлөлтийг хянах шинжилгээний арга аргачлал, хяналт шинжилгээ хийх хугацаа, сорьц авах болох хэмжилт хийх цэгийн байршил, баримтлах стандартууд зэргийг тодорхойлно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчноо хамгаалах, орон нутгийн захиргаа, хяналтын болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой. ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө. Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай.

Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг Эс Жи Эс Ай Эм Эм И Монголиа ХХК хариуцах болно.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамж зэргийг ажлын хэмжээг хэмжих нэгж, нэгжийн үнэ, нийт зардал, баримтлах стандарт, аргазүй, аргачлалын хамт тусгаж боловсруулан оруулна. Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лабораторийн талбайн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, төслийн талбай болон түүний орчны бүсийн талбайг хамран байгаль орчны хяналт шинжилгээг жил бүр тогтмол хийж байх хэрэгтэй.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаарын чанар	Нүүрстөрөгчийн исэл, Хүхэрт устөрөгч Азотын давхар исэл, тоосжилт	Ажлын байранд	Жил бүр нэг удаа. Шаардлагатай тохиолдолд тухай бүрт нь.	97.0	97.0 мян.төг	<ul style="list-style-type: none"> – MNS3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага – MNS0017-2-3-16:1988. Агаар мандал-Хот, суурингийн агаарын бохирдлын шинжилгээ – MNS3384:1982. Агаар мандал-Агаарын дээжилт шинжилгээ – MNS3113:1981. Хорт утааны ялгаралтыг хэмжих арга – MNS5061:2001. Нүүрс хүчлийн хий-CO₂ тодорхойлох эзэлхүүний арга – MNS0012-014:1991. Ажлын байрны агаар-Бичил орчинг шинжлэх арга
Хөрсөн бүрхэвч	Хөрсний хүнд элементийн агууламж ICP 57	Төсөл хэрэгжих талбайд 2 цэгт	Жилд нэг удаа	Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 45.0 мян.төг <i>*Эс жи Эс лаб ХХК үнэ авав.</i>	90,0	<ul style="list-style-type: none"> – MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл – MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох – MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам – MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх
Усан орчин	Усны ерөнхий химийн шинжилгээ		Жилд 1 удаа	Усны ерөнхий химийн шинжилгээ 20.0 мян.төг		<ul style="list-style-type: none"> – MNS0900:2005 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ – MNS3935:1986 Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

		усны эх үүсвэрээс ,		Усны 23 элемент хүнд металлын шинжилгээ 63.0 мян.төг <i>*УСУГ итгэмжлээгдсэн лабораторийн үнэ.</i>	63 мян.төг	<ul style="list-style-type: none"> - MNS3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх - MNS4432:1997 Ундны ус-Хуурай үлдэгдлийн хэмжээг тодорхойлох - MNS3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх - MNS5667-10:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах - MNS5667-2:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг Дээж авах арга - MNS4867:1999 Усны чанар-Дээж авах-3-р бүлэг Авсан дээжийг зөөвөрлөх, хадгалах арга
Ажиллагсдын эрүүл мэндийн хяналт үнэлгээ	Мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвтэй гэрээ байгуулж ажиллана.		Жил бүр	хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хөтөлбөрт тусгагдсан.		Ажлын байрны нөхцөл, эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл болон аюулгүй ажиллагааны талаар баримталдаг Монгол улсын стандартууд
	Нийт				250 мян.төг	

БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, төг	Хариуцагч
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөнө	Төслийн хугацаанд	Дотоод төлөвлөлтөөр	Үйл ажиллагааны менежер
2.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж сайтуудад 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааг ХЭААБО мэргэжилтэн өгөх	9 сард	500 000	ХЭАААБО-ны ажилтан
3.	Лабораторийн байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчныг хамгаалах зорилгоор байгаль орчны мэргэжилтэн, холбогдох байгууллагаа мэргэжлийн зөвлөгөө, зөвлөмж авч ажиллах.	Төсөл хэрэгжих хугацаанд	Дотоод төлөвлөлтөөр	ХЭАААБО-ны ажилтан
4.	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас хэрэгсэл болон болзошгүй галын ажилгүй ажиллагааны багаж хэрэгслээр хангана.	Төсөл хэрэгжих хугацаанд	Үйл ажиллагааны зардалд орсон	ХЭАААБО-ны ажилтан
5.	Дүүргээс зохион байгуулж буй урлаг, спортын арга хэмжээг дэмжиж ажиллах	Төслийн хугацаанд	Дотоод төлөвлөлтөөр	Компанийн захирал
6.	Ажилчдыг эмнэлгийн анхан шатны үзлэгт хамруулах	1 жилд 1 удаа	Дотоод төлөвлөлтөөр	ХЭАААБО-ны ажилтан
7.	Эрх бүхий байгууллагатай хог хаягдлын гэрээ байгуулах	-	-	Компанийн захирал
Дүн			500'000	

БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Нийт хийгдсэн ажлуудыг нэгтгэн дүгнэж хэрэгжүүлж эхэлсэн талаар БГД-н 20 дугаар хорооны иргэдийн төлөөллийн хурал, БГД-н Байгаль орчны газарт танилцуулга хийхээр төлөвлөсөн. Мөн тухайн жилийн биелэлтийн тайланг 2024 оны 11-р сарын 1-ны өдөр БОАЖЯ болон БГД-н ЗДТГ-т хүргэн өгөхөөр төлөвлөсөн.

Хүснэгт 12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардлын задаргаа

Хугацаа	Нөлөөлөлд өртөгч оршин суугчдад танилцуулах ажил	Зардал	Зохион байгуулах хүний албан тушаал
2024.10.10	БГД-иргэдийн хурал, ЗДТГ-ын мэргэжилтэн, холбогдох мэргэжлийн газар дээр нь танилцуулах	500'000төг	ХЭАААБО-ны ажилтан
2024.11.01	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ, БГД-н байгаль орчны газар болон БГД-н ЗДТГ-т хүргэн өгч байна.	Компаний дотоод төлөвлөлтөөр	ХЭАААБО-ны ажилтан
	Нийт зардал	500'000 төг	

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ, ДҮГНЭЛТ

Эс Жи Эс Ай Эм Эм И Монголиа ХХК-н хэрэгжүүлж буй геохими, нүүрсний лабораторийн талбай нь Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 20 дугаар хороо, үйлдвэрийн тойргийн 101 тоот үйлдвэрийн бүсэд оршино. Монгол улсын 9019068026 тоот улсын бүртгэлийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй “Эс Жи Эс Ай Эм Эм И Монголиа” ХХК нь БГД-н 20 дугаар хорооны үйлдвэрийн тойргийн 101 тоотод байрлах Өнжин уул ХХК-н эзэмшлийн талбайг түрээслэн үйл ажиллагаагаа явуулдаг.

“Эс жи эс ай эм эм и Монголиа” ХХК-ийн “Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лаборатори” төсөл нь геологийн хайгуул судалгаа, уул уурхайн нээлт, баяжуулан боловсруулалтад шаардагдах бүх төрлийн судалгаа шинжилгээг хийдэг бөгөөд үүнд: геохимийн чулуулаг, хөрс, тунамал болон органик бодисын шинжилгээнүүд, ховор, хүнд металлууд болох Cu, Pb, Zn, Ag, Au, Sb, Bi, Hg зэргийг илрүүлэн тогтоох, бүтээгдэхүүний чанарын шинжилгээ, чийгшил, үнсжилт, дэгдэмхий бодисын агууламж зэрэг шинжилгээ багтдаг.

Дараах үйлчилгээ, шинжилгээг мөн хийж гүйцэтгэдэг. Үүнд:

- Ус, эрчим хүч, уул уурхайн бүтээгдэхүүн, бус нутгийн геохимийн судалгаа, ахуйн төрлийн геохимийн үнэлгээ, чулуулаг болон эрдэс тодруулах, чулуулгийн механикийн туршилт шинжилгээ, эрдэнэс хаш тодруулах, геохими болон хайлуулалтын аргаар алт ба бусад суурь металлуудын агуулгыг тодорхойлох
- Хөрсний иж бүрэн шинжилгээ, судалгаа туршилтын ажлууд, байгаль орчны бохирдлын болон хаягдал бодис, ус гоо сайхны бүтээгдэхүүний шинжилгээ, хаягдал дахь ашигт элемент ашиглах туршилт
- Чулуулаг хөрсний лаборатори шинжилгээ, хар, өнгөт, үнэт, ховор металлын уурхай, сийрэгжилт элементийн уурхай, ховор шорооны уурхай, цацраг идэвхит чулуулаг, чулуулгийн механик зүй, шороон ажил, зуурмагийн материал, ханын материал, усны хамгаалалтын материал, цемент, барилгын арматур зэргийн дээж бүтээгдэхүүнд лаборатори шинжилгээ хийх.
- Нүүрсний дээжний хөвүүлэн баяжуулах туршилт хийх төмөр манган зэрэг эрдсийн соронзон ялгалтын туршилт
- Баяжуулах үйлдвэрийн төсөл төлөвлөгөө зохиох, үйлдвэрлэлийн индексийг тохируулах, баяжуулах үйлдвэрийн мэргэжил технологийг шинэчилж өөрчлөх, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх.
- Эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдлын урьдчилсан үнэлгээ, хүлээн авах үнэлгээ

Баяжуулах туршилт шинжилгээ, уул уурхайн олборлолт ашиглалтын төсөл төлөвлөгөө, олборлолт ашиглалтын аюулгүй ажиллагааны дүрэм, техник эдийн засгийн үндэслэл, эрчим хүч хэмнэх үнэлгээ, баяжуулах үйлдвэрийн төлөвлөгөө, үйлдвэрийн индексийг тохируулах зэрэг цогц үйлчилгээ үзүүлнэ.

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Тус компани нь газрын ашигт элементийн тодруулга, нүүрсний чанарын шинжилгээ, чулуулгийн эрдсийн шинжилгээ, чулуулаг хөрсний шинжилгээ, нефтийн шинжилгээ зэрэг бүх төрлийн шинжилгээ, баяжуулах туршилт хийх бөгөөд өөрийн үйл ажиллагааны хэрэгцээнд дээж боловсруулах урвалжийн зориулалттай химийн бодисуудыг импортын болон дотоодын нийлүүлэгчээс сонгон шалгаруулалтаар худалдан авч, эрдсийн шинжилгээ судалгаанд жилд 50 гаруй сая төгрөгийн химийн бодис хэрэглэдэг. Тус лабораторийн тоног төхөөрөмж болон шинжилгээ хийх үзүүлэлт нэмэгдсэн тул 2022 оноос 221 бодис, урвалж импортлохоор төлөвлөж байна.

“Эс Жи Эс Ай Эм Эм И монголиа” ХХК нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 Дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар шинэчлэн баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лабораторийн төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө гэж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.8-д заасан төлөвлөгөөг ойлгоно. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын хянаж баталсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн байгаль орчны үндсэн баримт бичиг болно.

“Эс Жи Эс Ай Эм Эм И монголиа” ХХК ХХК-ийн Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лабораторийн төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нөхөн сэргээх, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгалаа.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд галын хор, гал унтраах хэрэгслээр хангах, усан хангамжаа хангаж буй усанд хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх, технологийн хэрэгцээнд ашигласан усыг цэвэршүүлэн саармагжуулах, агуулахын орчны зам талбайг хатуу хучилттай болгох зэрэг ажлын төлөвлөлөө.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний, орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд нийт талбайн сул чөлөөтэй хэсэг буюу агуулахын эргэн тойронд мод бут сөөг тарих нөхөн сэргээх ажлыг MNS 4918:2000 стандартын дагуу ургамалжуулалт, ногоон байгууламж, мод тарих ажлыг үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөсөн.

Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лаборатори төслийн талбайд дахиж шинээр барилга байгууламж баригдахгүй тул түүх соёлын арга хэмжээг төлөвлөөгүй болно.

Энэхүү төслийн агуулах талбай нь Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороо, 9720 м² талбайд байрлана. “Эс Жи Эм-Ай Эм И Монголиа ” ХХК-ийн Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лабораторийн үйл ажиллагааны явцад ажилчдын

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

аюулгүй байх орчин нөхцөлийг ханган хөдөлмөр хамгаалал, осол аюулгүйн талаарх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лаборатори төслийн хүрээнд ахуйн хэрэглээний хог хаягдлыг ангилж Баянгол дүүргийн ТҮК сард 2 удаа тээвэрлүүлэхээр төлөвлөсөн. Мөн аюултай хог хаягдлыг Цэцүүх трейд ХХК-тай гэрээ байгуулан улиралд 1 удаа тээвэрлүүлэхээр төлөвлөж байна.

Геохими, нүүрсний шинжилгээний иж бүрэн лабораторийн үйл ажиллагаанд 223 нэр төрлийн химийн бодис ашиглана.

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг **“Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”** гэнэ. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тухайн төслөөс байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг /ус, хөрс, ургамал гэх мэт/ тус бүрд гарах бохирдол, аливаа өөрчлөлтийг хянах шинжилгээний арга аргачлал, хяналт шинжилгээ хийх хугацаа, сорьц авах болох хэмжилт хийх цэгийн байршил, баримтлах стандартууд зэргийг тодорхойлно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчноо хамгаалах, орон нутгийн захиргаа, хяналтын болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой. ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө. Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай.

Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг Эс Жи Эс Ай Эм Эм И Монголиа ХХК хариуцах болно.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамж зэргийг ажлын хэмжээг хэмжих нэгж, нэгжийн үнэ, нийт зардал, баримтлах стандарт, аргазүй, аргачлалын хамт тусгаж боловсруулан оруулна. Геохими,

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

нүүрсний шинжилгээний иж бүрэн лабораторийн талбайн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, төслийн талбай болон түүний орчны бүсийн талбайг хамран байгаль орчны хяналт шинжилгээг жил бүр тогтмол хийж байх хэрэгтэй.

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн.

Нийт хийгдсэн ажлуудыг нэгтгэн дүгнэж хэрэгжүүлж эхэлсэн талаар БГД-н 20 дугаар хорооны иргэдийн төлөөллийн хурал, БГД-н Байгаль орчны газарт танилцуулга хийхээр төлөвлөсөн. Мөн тухайн жилийн биелэлтийн тайланг 2024 оны 11-р сарын 1-ны өдөр БОАЖЯ болон БГД-н ЗДТГ-т хүргэн өгөхөөр төлөвлөсөн.

Хүснэгт 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

№	Зардлын утга	Нийт зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	3060 000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	410 000
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	400 000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1600 000
6	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1280 000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	250 000
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	500 000
9	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөө	500 000
	2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	8000 000

2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **8000 000** төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө болгож 4000 000 төгрөгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9,15 дахь заалтад зааснаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулна.